

**“Оюуны хөгжил-IQ”, “Сэтгэх чадвар-TS”-ын дугуйлангийн суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах гэрээ**

Энэхүү хамтын ажиллагааны гэрээг нэг талаас “Оюуны хөгжил-IQ” дугуйланг төлөөлж \_\_\_\_\_ ажилтай \_\_\_\_\_ /цаашид “IQ дугуйлан багш” гэх/ нөгөө талаас \_\_\_\_\_ хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийг төлөөлж \_\_\_\_\_ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Гэрээнд оролцогч талууд Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал (тушаал А/659) болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

**Нэг. Ерөнхий зүйл**

1. Энэхүү гэрээний зорилго нь сэтгэх чадвар хөгжүүлэх 48 цагийн хөтөлбөртэй IQ дугуйланд сурагчийг суралцуулах, хөгжүүлэх үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулж, дугуйлангийн сургалтыг чанартай зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл, сайн дурын үндсэн дээр хамтран ажиллахад чиглэнэ.

**Хоёр. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг**

1. Хүүхдийн хөгжлийн ахиц болон сургалтын үр дүнтэй танилцах /хичээлийн үнэлгээний сорилууд, сургалтын явц, дүгнэлт хичээл/.
2. Хүүхэд хөгжүүлэх чиглэлээр багштай хамтран ажиллах, суралцахтай холбоотой асуудлаар санал хүсэлт гаргах.
3. Сургалтын хэрэглэгдэхүүнийг /тухайн түвшний сурах бичиг, тоглоом, үнэлгээний сорил/ дугуйлангийн багшаас бүрэн хүлээж авах.
4. Суралцагчийг дугуйлангийн хичээл эхлэхээс өмнө анги /сургууль/-д хүргэж өгөх, хичээл тарах үед анги /сургууль/-аас ирж авах буюу “ГАРААС-ГАРТ” журмыг баримтална.
5. Сургалтын төлбөрийг заасан хугацаанд төлж барагдуулна.

**Гурав. Дугуйлангийн багшийн эрх, үүрэг:**

1. Сургалтыг баталсан хөтөлбөрийн дагуу хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан үр дүнтэй хичээллүүлэх.
2. Хүүхдийн олон талт оюуны чадварыг нээн илрүүлж, тэдэнд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах.
3. Дугуйлангийн хичээлийн явцад суралцагчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
4. Суралцагчийг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл, сайн дурын үндсэн дээр Оюуны хөгжил IQ хичээлд хамруулна.
5. Дугуйлангийн явц болон төгсгөлд хичээлийн үр дүнг эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.
6. Суралцагчийг дугуйлангийн хичээл эхлэхээс өмнө анги /сургууль/-д эцэг эх, асран хамгаалагчаас авч, хичээл тарах үед эцэг эх, асран хамгаалагчид өгөх буюу “ГАРААС-ГАРТ” журмыг баримтална.

**Гэрээ байгуулсан:**

Дугуйлангийн багш: ..... / .....

Эцэг эх/асран хамгаалагч: ..... / .....

Хянасан: ..... / .....